

“Хамтарсан бэлтгэл” болон “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт”-ын тухай Санамж бичиг

Монгол улсын Пара-Байт харвааны холбоо /цаашид “Монголын Пара-Байт харвааны холбоо” гэх/ болон Япон улсын Нийгата мужийн Цүбамэ хот /цаашид “Цүбамэ хот” гэх/ нар Хамтарсан бэлтгэл болон 2020 оны Токио Олимп, Паралимп тэмцээн /цаашид “Токио-2020 Олимп, Паралимп” гэх/-ийн өмнө сургуулилалт хийх талаар дараах Санамж бичигт гарын үсэг зурав.

Үүнд:

- I. Монголын Пара-Байт харвааны холбоо нь “Токио-2020 Олимп, Паралимп”-ийн өмнө Цүбамэ хотод бэлтгэл хийнэ.
- II. Цүбамэ хот нь Монголын Пара-Байт харвааны холбоог “Хамтарсан бэлтгэл”, “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт” хийхэд найрсагаар хүлээн авч хичээнгүйлэн дэмжиж туслана.
- III. Монголын Пара-Байт харвааны холбоо нь “Хамтарсан бэлтгэл”, “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт” хийхэд дараах асуудалд анхаарч ажиллана.
 - (1) “Токио-2020 Олимп, Паралимп”-д монголоос олон тамирчид оролцохын төлөө хичээнэ.
 - (2) “Хамтарсан бэлтгэл”, “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт”-ыг хийхэд шаардлагатай мэдээллийг Цүбамэ хоттой тогтмол солилцоно.
 - (3) “Хамтарсан бэлтгэл”-н үеэр зохион байгуулагдах бусад хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.
 - (4) Токио-2020 Олимп, Паралимпийн дараа цаашид ч Цүбамэ хоттой хамтын ажиллагаатай байна.
- IV. Цүбамэ хот нь “Хамтарсан бэлтгэл”, “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт”-ийг хийхэд дараах асуудалд анхаарч ажиллана.
 - (1) Шаардлагатай тоноглол болон сургуулилалтын орчин нөхцлийг бүрдүүлнэ.
 - (2) Тамирчидыг байрлах хугацаанд бусад хамтын ажиллагаануудыг зохион байгуулна.
- V. Талууд хэл болон соёлын ялгаатай байдалд харилцан хүндлэлтэй хандаж “Хамтарсан бэлтгэл”, “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт”-аас гадна бусад хамтын ажиллагааг хэрэгжүүлж хоёр орны найрамдалт харилцаанд хувь нэмэр оруулахад анхаарч ажиллана.
- VI. “Хамтарсан бэлтгэл”-д гарах зардал, ашиглах байгууламж, сургуулилалт хийх хугацаа, бэлтгэлд хамрагдах хүний тоо болон харилцан хүлээх үүрэг зэргийг “Хамтарсан бэлтгэл”-ийн өмнө талууд хэлэлцэж тохирч байх.
- VII. “Токио-2020 Олимп, Паралимпийн өмнөх сургуулилалт”-д гарах зардал, ашиглах байгууламж, сургуулилалт хийх хугацаа, бэлтгэлд хамрагдах хүний тоо болон харилцан хүлээх үүрэг зэргийг 2019 оны 12 сар хүртэл хэлэлцэж, тохиролцоонд гарын үсэг зурах.
- VIII. Тус Санамж бичигт тусгагдаагүй болон тусгагдсан агуулгын талаар хоёр тал хэлэлцэж, шийдвэрлэх болно.
- IX. Талууд энэхүү Санамж бичгийн нууцлалыг чандлан сахих болно.

Ийнхүү Санамж бичгийг япон болон монгол хэлээр үйлдэж талууд Цүбамэ хотод гарын үсэг зурж батлав. Талууд Санамж бичгийн хэл тус бүрийн нэг эх хувийг хадгална.

2016 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр



Япон улс, Нийгата муж, Цүбамэ хотын
Дарга СУЗУКИ ЦУТОМУ



Монгол улс, Пара-Байт харвааны холбооны
Ерөнхийлөгч ДАМБАДОНДОГИЙН БААТАРЖАВ